



ХЭНТИЙ АЙМГИЙН
ДЭЛГЭРХААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 05 сарын 04 өдөр

Дугаар 2/51

Дэлгэрхаан сум

Төрийн албан хаагчийн зөвлөгөөн зохион
байгуулах арга хэмжээнд зардал
гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, сумын иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2025 оны 12 дугаар сарын 19-ний 23 дугаар тогтоолын 1 хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Төрийн албан хаагчдын зөвлөгөөн зохион байгуулах ажлын хүрээнд шаардагдах зардлыг Сумын Засаг даргын мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардлын 4.3.2.1 дэх заалт болох Иргэдийн оролцоот-Нэг Хэнтий арга хэмжээний зардлаас 1,599,000 (нэг сая таван зуун ерэн есөн мянга) төгрөгийг зарцуулсугай.

2.Зөвлөгөөнд шаардагдах зардлыг хавсралтаар баталсугай.

3.Үйл ажиллагааны зурагт тайлан холбогдох мэдээллийг гаргахыг нийгмийн бодлогын асуудал хариуцсан мэргэжилтэн (Ц.Золзаяа)-д даалгасугай.

4.Зардалд шаардагдах 1,599,000 (нэг сая таван зуун ерэн есөн мянга) төгрөгийг Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн зардлаас гаргахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Урангоо), нягтлан бодогч (О.Анхцэцэг) нарт зөвшөөрсүгэй.

ДАРГА



Б.ЭНХ-АМГАЛАН

2328010101

Засаг даргын 2026 оны 05 дүгээр сарын 04 ний
өдрийн 1/51 дугаар захирамжийн хавсралт



ЗАРДЛЫН ТООЦОО

д/д	Зардлын нэр	Хэмжих нэгж	Тоо	Нэг бүрийн үнэ	Бүгд үнэ
1	Төрийн албан хаагчийн энгэрийн тэмдэг	ширхэг	130	10,000	1,300,000
2	Цайны зардал			2,300	299,000
	Дүн				2,599,000

